

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

Нийслэлийн Эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1-д “Нийслэл нь өөрийн туг, сүлд тэмдэгтэй мөн зүйлийн 2-д “Нийслэлийн туг, сүлд тэмдгийн загвар, хэрэглэх журмыг Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтооно. “гэж заасан.

Уг заалтыг үндэслэн Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 1995 онд нийслэлийн Сүлд, далбааны загвар, хэрэглэх журмыг баталсан.

Нийслэлийн иргэдийг төр, нийгмийг удирдах хэрэгт оролцуулдаг гол хэлбэр, нийслэлийн удирдлагын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг хурал юм.

Монгол оронд ардын хувьсгал ялсан цагаас хойш нийслэлийн Хурал 18 насанд хүрсэн нийт иргэдээс шууд сонгогддог Төлөөллийн байгууллага байсаар иржээ. Нийслэл Улаанбаатар хотыг Хурал нь 1989 оноос гүйцэтгэх засаглалаасаа тусгаарлан бие дааж дарга, орлогч дарга, нарийн бичгийн дарга, Тэргүүлэгчидтэй болжээ.

Анх 1924 онд “Цаг зуурын хурал” нэртэй байгуулагдсан 45 төлөөлөгчид сонгогджээ. Дараа нь “Хотын хурал”, “1948 оноос “Улаанбаатар хотын хөдөлмөрчин Төлөөлөгчдийн Хурал”, 1962 оноос “Улаанбаатар хотын Ардын Депутатуудын Хурал”, 1989 оноос “Улаанбаатар хотын Ардын хурал”, 1992 оноос “Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал”, нэртэйгээр хөгжиж ирсэн байна. 1924 онд 40, 1928 онд 251, 1952 онд 166, 1970-1980 онуудад 225, 1990 онд 150, 1992 онд 72, 1996-2008 онд 40 төлөөлөгчидтэй байжээ.

Хотын Ардын Их хурлыг сонгох анхны чөлөөт сонгууль 1990 оны 06 дугаар сард болж 150 мандатын төлөө МАХН, МоАН, МҮДН, МСДН, нам бусчуудын төлөөллөөс нэр дэвшсэн 600 гаруй хүн өрсөлдөж, сонгууль 2-3 үе шаттайгаар гурван сар болжээ. Улаанбаатар хотын анхдугаар чуулган 9 сард хуралдаж, хотын АХ-ын бүтэц бүрэлдэхүүнийг сонгон баталжээ.

БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдээс, Улаанбаатар хотын АХ-ын Тэргүүлэгчдийн даргад Гүйцэтгэх захиргааны даргыг хавсаргах шийдвэр гарч Гүйцэтгэх Захиргааны даргыг хавсаргах шийдвэр гарч, Хурлын Тэргүүлэгчдийн даргаар Л.Энэбиш, орлогч даргад Я.Мөнхжаргал, нарийн бичгийн даргад Г.Маналжав, Тэргүүлэгч гишүүдэд ЭМЯ-ны орлогч сайд, С.Гончиг, Улаанбаатар хотын МАХН-ын хорооны даргад Б.Даш-Ёндон, Улаанбаатар хотын МХЗЭ-ийн хорооны дарга Б.Болд, УБДС-н багш С.Данзан, Барилгын цэргийн удирдах газрын орлогч дарга Д.Дорж, ГХДС-ийн багш Ж.Занаа, Улаанбаатар хотын МҮДН-н дарга Д.Мөнхбаатар, Улаанбаатар хотын Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Ж.Эрдэнэчимэг, Барилгын зургийн институтын архитектор З.Пүрэвсүрэн, Ардын эрх сониний тоймч Х.Дашзэвэг нар сонгогдсон.

Улаанбаатар хотын АДХ-ын Тэргүүлэгчдийн дарга Л.Лантуу албан тушаалаа орхих өргөдөл гаргасаны дагуу АДХ-ын Тэргүүлэгч гишүүн О.Амархүүг сонгожээ.

1992 онд нийслэлийн ИТХ-н 72 хүний бүрэлдэхүүнтэй шинээр эмхлэн байгуулагджээ. Нийслэлийн ИТХ-д МАХН 58, МҮДН 3, МСДН 1, нам бусчуудын төлөөлөл 10 суудал авчээ.

Улаанбаатар хотын ИТХ-н Тэргүүлэгчдийн даргаар Ж.Ядамсүрэн, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Ц.Маналжав, Тэргүүлэгч гишүүдэд Улаанбаатар хотын МАХН-ын дарга Г.Өлзий, Хотын цагдаагийн газрын орлогч дарга Л.Гарамжил, хотын эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Ж.Эрдэнэчимэг, “Алтан тариа”ХК-ийн захирал С.Цэдэв, “Монгол мэдлэг” дээд сургуулийн захирал Г.Дашням, Нийслэлийн Засаг даргын орлогч П.Ганбаатар, Удирдлагын Академийн багш А.Цанжид нар сонгогджээ.

Нийслэлийн ИТХ-ыг сонгох ээлжит сонгууль явагдаж ИТХ-ын 40 суудлаас МАХН 39, МБНН 1 суудал авчээ, Нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар Т.Билэгт “Тэргүүлэгчдийн

нарийн бичгийн даргаар Ц.Маналжав, Тэргүүлэгчээр Улаанбаатар хотын МАХН-ын хорооны дэд дарга Д.Баасансүрэн, хотын ерөнхий менежер Т.Бадамжунай, дэд бүтцийн дэд сайд У.Уламбаяр, Худалдаа үйдвэрлэлийн дээд сургуулийн захирал С.Нямзагд, МИАТ компанийн дэд захирал Ц.Баатарсүрэн, Улаанбаатар хотын эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга П.Алтанцэцэг, БОЯ-ны газрын орлогч дарга Г.Энхтүвшин нар сонгогдон ажиллажээ.

Нийслэлийн ИТХ-аас нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар М.Энхболдыг дахин томилжээ.

2004 онд Нийслэлийн ИТХ-ын ээлжит сонгуулиар Нийслэл дүүргийн ИТХ-ын 275 мандатын төлөө 754 хүн өрсөлдөж, нийслэлийн ИТХ-ын 40 мандатын 37, дүүргийн ИТХ-ын 235 мандатын 232-ыг МАХН авч үнэмлэхүй ялалт байгуулсан. Нийслэлийн ИТХ-ын даргаар УИХ-ын гишүүн асан Н.Болормаа, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Т.Билэгт, Тэргүүлэгчээр хотын ерөнхий менежер Г.Мөнхбаяр, Нийслэлийн татварын газрын дэд дарга Я.Аюушжав, Улаанбаатар хотын МАХН-ын хорооны дэд дарга Д.Баасансүрэн, “Гэр бүл, хөгжил” төвийн тэргүүн Б.Ундармаа, “Сэрүүлэг” сонины эрхлэгч С.Баярмөнх, Улаанбаатар хотын МҮАН-ын дарга Ш.Алтангэрэл, Гадаадын хөрөнгө оруулалтын газрын дэд дарга С.Отгонбат нарыг сонгожээ.

Нийслэлийн ИТХ-аас нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар М.Энхболдыг дахин томилсон ба 2005 онд УИХ-ын гишүүнээр сонгогдсон тул Засаг даргаар Ц.Батбаярыг томилжээ. Мөн нийслэлийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Т.Билэгт Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргаар ажиллах болсноор ИТХ-ын бүрэн эрхийн хугацаанд Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Ж.Жанцан, П.Хангал нар ажилласан.

2008 онд нийслэлийн ИТХ-ыг сонгох сонгуульд сонгогчдын ирц хүрэлцэхгүйн улмаас дахин сонгууль болж ИТХ-д МАХН-аас 36, МҮАН-аас 9 нэр дэвшигч төлөөлөгчөөр сонгогдсон.

Нийслэлийн ИТХ-ын даргаар нийслэлийн Засаг дарга Т.Билэгт, Хурлын нарийн бичгийн даргаар Ж.Батбаясгалан, Тэргүүлэгч гишүүдээр МАХН-ын хэвлэл мэдээллийн албаны дарга Д.Амарбаясгалан, БЗД-ийн Засаг дарга Б.Батзориг, “АПУ трейдинг” компанийн ерөнхий захирал П.Батчимэг, “Сээкл” компанийн Оргил худалдааны төвийн ерөнхий захирал Ж.Ганбаатар, Б.Пүрэвжав, Нийслэлийн Засаг даргын зөвлөх П.Хангал, Нийслэлийн Засаг даргын орлогч Ц.Цогзолмаа, “Таван эрдэнэ” компанийг ерөнхий захирал Б.Энх-Амгалан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх Л.Эрхэмбаяр нарыг сонгожээ. Нийслэлийн ИТХ-аас нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар Г.Мөнхбаярыг томилсон байна.

2012 онд Нийслэлийн ИТХ-ын сонгууль УИХ-ын сонгуультай нэг зэрэг явагджээ. Нийслэлийн ИТХ-д АН 26, МАН 14, МАХН, МҮАН-ын Шударга ёс эвсэл 4 суудал авчээ. Нийслэлийн ИТХ-аас Хурлын Тэргүүлэгчдийг 11 хүний бүрэлдэхүүнтэй сонгож даргаар Д.Баттулгыг баталжээ.

Нийслэлийн ИТХ-аас Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаар Э.Бат-Үүлийг томилжээ.

2016 оны Нийслэлийн ИТХ-ын сонгуульд МАН олонхи болж, нийт 45 суудлын 34 МАН, 11 суудлыг АН-аас нэр дэвшигчид авч нийт 286 нэр дэвшигч өрсөлджээ. Нийслэлийн ИТХ-н сонгуулиар ИТХ-ын даргаар Ц.Сандуйг, Нийслэлийн Засаг даргаар С.Батболд, нарыг тус тус томилсон.

НИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргаар ажиллаж байсан Бөхчулууны Энхболдыг чөлөөлж түүний оронд Мягмарсүрэн овогтой Буяндэлгэрийг НИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны даргын түр орлон гүйцэтгэгчээр томилох шийдвэр гаргасан

НИТХ-ын хурлын дарга Ц. Сандуй хуралдаанаар хороо, дэд хороодыг байгуулж, дарга нарын сонгоно гэдгийг танилцуулсан. Хороод, дэд хороог байгуулахдаа төрийн албаны залгамж бодлогыг хадгалах зарчим барьсаны зэрэгцээ Нийслэлийн МАН-ын хорооны 2016 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор “Аз жаргалтай хот” хороог шинээр байгуулж байгааг онцолсон юм. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь бодлогын 7 хороо, 11 дэд хороотой ажиллахаар тогтсон.

Үүнд: “Аз жаргалтай хот” хорооны даргаар Р.Дагва

Хот төлөвлөлт, байршил, суурьшлыг зохицуулах дэд хорооны даргаар Б.Батнасан

Орон Орон сууцны хангамжийн дэд хорооны даргаар Х.Хатанбаатар

Ухаалаг Улаанбаатар дэд хорооны даргаар М.Халиунбат

Хууль зүй, төрийн байгуулалтын хорооны даргаар С.Мөнхчулуун

Хүний эрх, ёс зүйн дэд хорооны даргаар Ц.Одонтунгалаг

Эрх зүйн орчны шинэтгэлийн хорооны дэд даргаар Ж.Батсайхан

Нийгмийн хөгжлийн хорооны даргаар Д.Мөнхжаргал

Иргэдийн амжиргааны түвшинг дээшлүүлэх хорооны даргаар Б.Мөнхбат

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хорооны даргаар М.Эрдэнэтуяа

Санхүү, төсөв, эдийн засгийн хорооны даргаар С.Амарсайхан

Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны даргаар Б.Бадарсан

Хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны дэд хорооны даргаар Ч.Гантулга

Байгаль орчин, экологийн хорооны даргаар Л.Нарантуяа

Агаар, хөрс, усны бохирдлыг бууруулах дэд хорооны даргаар Ж.Алдаржавхлан

Ногоон байгууламжийг хөгжүүлэх дэд хорооны даргаар Б.Бямбадорж

Гэр хорооллын хөгжлийн хорооны даргаар Т.Батцогт

Өргөдлийн хорооны даргаар Б.Сүхбаатар нарыг тус тус ажиллуулахаар болсон.

НИТХ-ийн хуралдаанаар орон тооны бус 3 зөвлөл байгуулах тухай асуудлыг хэлэлцэн хурлын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий Зөвлөх зөвлөл, Эрдэмтдийн зөвлөл, Экспертийн зөвлөл байгуулсан.

Дээрх зөвлөлүүдийг байгуулснаар Улаанбаатар хотын хөгжлийн бодлогыг тодорхойлохдоо шинжлэх ухаан, судалгаанд тулгуурлан, салбартаа тэргүүлэгч эрдэмтдийн

санал санаачлагыг сонсож, төрийн ажлын дадлага туршлагатай эрхмүүдийн зөвлөгөөнд суурилан боловсруулах шийдвэр гаргаж байгаагаа НИТХ-ын дарга Ц. Сандуй онцолсон.

Аливаа төрийн ажлыг явуулахдаа судалгаа шинжилгээнд тулгуурлан, алсын хараатай, бодлогын зарчмыг баримтлахаа "Аз жаргалтай хот" мөрийн хөтөлбөртний дагуу НИТХ-ын дэргэд орон тооны бус 3 зөвлөлийг байгуулж байна. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ажиллаж байсан ажлын дадлага туршлагатай хүмүүсээр Зөвлөх зөвлөлийг байгуулж, Энэ зөвлөл нь 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажиллах болсон.

Зөвлөх зөвлөлийг дараах гишүүдтэйгээр байгууллаа.

Ж. Ядамсүрэн НИТХ -ын дарга 1992- 1996

Ц. Баасанжав НИТХ-ын дарга 1996 - 2000 он

Т. Билэгт НИТХ -ын дарга 2000 - 2004 , 2008 - 2012

Н. Болормаа НИТХ -ын дарга 2004 - 2007

Г. Мөнхбаяр НИТХ -ын дарга 2007 - 2008

Д. Баттулга НИТХ-ын дарга 2012 - 2016 он хүртэл ажиллаж байсан хүмүүс

багтаж байна. Харин Зөвлөх зөвлөлийн Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар 12 жил НИТХ -ын нарийн бичгийн даргаар ажилласан Г. Маналжавыг сонгожээ.

Эрдэмтдийн зөвлөл, экспертийн зөвлөлийн тухайд мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, доктор цолтой, стратегийн тэргүүлэх чиглэлээр дагнан судалгаа шинжилгээ хийсэн эрдэмтэн, зөвлөхүүдээс нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгож ажилуулж, Орон тооны хувьд 5 - 9 хүртэл гишүүнтэй байхаар Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчидийн хуралдаанаар шийдвэрлэсэн.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь одоо 45 төлөөлөгч, 11 тэргүүлэгч гишүүн, 5 ажлын хороо, 11 дэд хороотой үйл ажиллагаа явуулж байна.

Хурлын Ажлын алба нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Тэргүүлэгчдээс сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд баримталж, ажиллах үндсэн чиглэл, жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг бүрэн хэрэгжүүлэх, хурлын Тэргүүлэгч, Төлөөлөгчдийг мэдээ мэдээллээр хангах, тэдэнд туслах, үүргийг гүйцэтгэдэг.

Хурлын ажлын алба нь Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд хурлын ажлын албаны дарга, зохион байгуулалтын хэлтсийн дарга, зөвлөх ажилтан 11 орон тоотойгоор ажиллаж байна.

Одоо Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал нь 45 төлөөлөгч, 9 Тэргүүлэгчтэй, орон тооны дарга, нарийн бичгийн дарга, ажлын албатайгаар ажиллаж байна.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, тэргүүлэгчдээс сонгуулийн бүрэн эрхийн хугацаанд баримталж ажиллах үйл ажиллагааны үндсэн чиглэлээс

Нийслэл хотын нийгэм, эдийн засаг, хот байгуулалтын хөгжлийн ойрын жилүүдийн бодлогыг тодорхойлон, түүнийг хэрэгжүүлэхэд иргэд, хамт олны бүтээлч санаачлага, идэвхтэй оролцоонд тулгуурлан ажиллах зарчмыг баримталж, хүний хөгжлийг бүх талаар хангах боломж

нөхцөлийг бий болгох, нийслэлд нутгийн өөрөө удирдах ёсыг хөгжүүлэх, нийслэлийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгож, бие даан ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэхэд Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны үндсэн зорилт оршино.